

Мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйл ба түүнтэй холбоотой зарим хүчин зүйлс

Н.Билгүүн¹, Д.Хонгорзул¹, Х.Тэргэл¹, Ж.Даваалхам², З.Хишигсүрэн¹, Д.Оюунсүрэн¹¹АШУҮИС-ийн АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим²ХӨСҮТ, ХДХВ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба

Цахим шуудан: Bilguun.n@mnuhs.edu.mn, Утас: 95005413

Түлхүүр үг:

Хамгаалалтгүй
хавьтал
Бэлгэвчний
хэрэглээ
БЗДХ
ХДХВ
Халдварт
өртөмхий байдал

Товч утга

Үндэслэл: Мансууруулах бодисын хэрэглээ нь бэлгийн эрсдэлт зан үйл, бэлгийн замаар дамжих халдварын эрсдэл, тухайлбал ХДХВ болон тэмбүүгийн халдварт өртөх магадлалыг эрс нэмэгдүүлдэг сэтгэц нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг юм. Олон улсын болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад, мансууруулах бодис хэрэглэгчид нь мансуурсан үедээ аливааг шүүн тунгаах, эрсдэлт нөхцөлд дүгнэлт хийх чадвар буурсанаас хамгаалалтгүй болон тохиолдлын бэлгийн хавьталд орох, олон хавьтагчтай байх, цусаар эсвэл бэлгийн замаар дамжих халдварт өртөх эрсдэл өндөр байдаг. Манай улсад мансууруулах бодис хэрэглэгчдийн бэлгийн эрсдэлт зан үйлийн талаар мэдээлэл хомс тул энэхүү эрсдэлт бүлгийн хүн амын дундах бэлгийн эрсдэлт зан үйл болон түүнтэй холбоотой хүчин зүйлсийг тодорхойлох нь уг судалгааг хийх үндэслэл болсон билээ.

Зорилго: Мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн түвшинг тогтоож, түүнд нөлөөлж буй хүн амзүй болон зан үйлийн хүчин зүйлсийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго чиглэсэн болно. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик агшингийн загвараар гүйцэтгэж, 181 оролцогчийг хамруулав. Мэдээллийг цуглуулахдаа урьдчилан боловсруулсан удирдамжийн дагуу зохион байгуулсан ганцаарчилсан ярилцлагын явцад хагас бүтэцчилсэн асуумж болон мансууруулах бодисын хэрэглээний эмгэгийг үнэлэх DAST (Drug Abuse Screening Test) сорилыг ашигласан болно. Мөн БЗДХ-ыг илрүүлэх лабораторийн түргэвчилсэн шинжилгээг ашиглалаа. Үр дүнг SPSS 27 программ ашиглан боловсруулсан ба хүчин зүйлсийн хамаарлыг χ^2 тест, Пирсоны корреляци болон олон хүчин зүйлийн шугаман регрессийн шинжилгээгээр баталгаажууллаа. Судалгааны ёсзүйн асуудлыг журмын дагуу шийдвэрлэсэн болно (№24-25/05-02). **Үр дүн:** Нийт оролцогчийн 12.2%-д бэлгийн эрсдэлт зан үйл илэрсэн бөгөөд бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр онооны дундаж 8.13 ± 4.40 байв. Статистик шинжилгээгээр хүйс, гэр бүлийн байдал (хамтран амьдрагчгүй байх), анхны бэлгийн хавьталд бэлгэвч хэрэглээгүй байдал нь эрсдэлт зан үйлтэй шууд хамааралтай байлаа ($p < 0.05$). Ялангуяа согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хавсарсан хэрэглээ нь бэлгийн эрсдэлийг үлэмж нэмэгдүүлж байв. Тухайлбал, согтууруулах ундааны нөлөөнд бэлгийн хавьталд орох давтамж болон сүүлийн нэг жилийн бэлгийн хавьтагчийн тоо ($r = 0.24$, $p < 0.01$) нь эрсдэлт зан үйлийн оноог урьдчилан таамаглах статистикийн ач холбогдол бүхий эерэг үзүүлэлт болж байна. **Дүгнэлт:** Мансууруулах бодис хэрэглэгчдийн бэлгийн эрсдэлт зан үйл нь зөвхөн бодисын хэрэглээнээс гадна архины хамаарал болон бэлгийн соёлын дутмаг байдлаас (хамгаалалтгүй хавьтал, олон хавьтагч) ихээхэн хамаарч байна. Иймд эрсдэлийг бууруулах интервенцийг боловсруулахдаа бодисын хамаарал болон бэлгийн эрүүл мэндийн зөвлөгөөг цогцоор нь хүргэх, БЗДХ-ын илрүүлэгт тогтмол хамруулах стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үндэслэл: Мансууруулах бодисын хэрэглээ нь дэлхий дахинаа сэтгэц нийгмийн эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлснээр, сүүлийн жилүүдэд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо өссөөр байгаа бөгөөд энэ нь бодисын хэрэглээний шууд хор нөлөөнөөс гадна халдварт өвчин, сэтгэцийн эмгэг, нийгмийн сөрөг үр дагаврыг нэмэгдүүлж байгаа юм¹. Ялангуяа мансууруулах бодис тарьж хэрэглэдэг болон өндөр эрсдэлтэй нөхцөлд хэрэглэдэг бүлгүүдийн дунд ХДХВ, вируст гепатит, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын эрсдэл өндөр хэвээр байгаа нь уг асуудал зөвхөн донтолын бус, нийгмийн эрүүл мэндийн өргөн хүрээний асуудал болохыг харуулж байна¹⁻⁴.

Мансууруулах бодис болон согтууруулах ундааны хэрэглээ нь бэлгийн эрсдэлт зан үйлтэй нягт холбоотойг олон улсын судалгааны үр дүнгүүд тогтвортой харуулсан байдаг. Leigh, Stall нар бодисын хэрэглээ нь хамгаалалтгүй бэлгийн хавьтал, олон хавьтагчтай байх, тохиолдлын бэлгийн хавьтал зэрэг ХДХВ-ийн эрсдэлтэй зан үйлтэй холбоотойг онцолсон⁵. Өсвөр үе, залуусыг хамарсан мета-анализын үр дүнд бодисын хэрэглээ болон бэлгийн эрсдэлт зан үйлийн хооронд статистикийн ач холбогдол бүхий эерэг холбоо байгааг харуулсан бөгөөд энэхүү холбоо янз бүрийн нас, нийгмийн бүлэгт давтагдан ажиглагджээ^{6,7}. Нигери, АНУ зэрэг улс орны судлаачдын хийсэн тойм болон мета-анализ судалгаанууд ч архины хэрэглээ ихсэх тусам хамгаалалтгүй хавьтал, олон хавьтагчтай байх, ХДХВ-ийн эрсдэлтэй зан үйл нэмэгддэгийг тогтоосон байдаг⁸⁻¹¹.

Мансууруулах сэргээгч төрлийн бодис, тэр дундаа метамфетамин хэрэглээ нь бэлгийн эрсдэлт зан үйлтэй илүү хүчтэй холбоотой болохыг олон судалгаанд тэмдэглэжээ. Метамфетамин хэрэглэдэг хүмүүсийн дунд хамгаалалтгүй бэлгийн хавьтал, олон хавьтагчтай байх, өндөр эрсдэлтэй хавьтагчтай бэлгийн харилцаанд орох, БЗДХ болон ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэл бусад бодистой харьцуулахад өндөр байдаг нь тогтоогдсон¹²⁻¹⁷.

Бэлгийн эрсдэлт бүлгийн, бодисыг судсаар тарьж хэрэглэдэг мансуурагчдын дунд БЗДХ-ын эрсдэл давхар өндөр байдгийг өмнөх судалгаанууд харуулсан байдаг^{4,18}. Kanno болон түүний хамтрагчид бодисыг тарьж хэрэглэдэг мансуурагчдын дундах БЗДХ нь дан ганц бэлгийн зан үйл төдийгүй мөн нийгмийн эмзэг байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжтэй холбоотой болохыг тэмдэглэсэн³. Brookmeyer болон түүний хамтрагчдын үндэсний хэмжээний судалгааны дүн тарьж хэрэглэдэг хүмүүсийн дунд бэлгийн эрсдэлт зан үйл болон БЗДХ өндөр түвшинд илэрч байгааг харуулсан бөгөөд энэ бүлэгт зүү, тариурын эрсдэл төдийгүй бэлгийн эрсдэлийг давхар үнэлэх шаардлагатайг онцолжээ². Бодисын хэрэглээтэй холбоотой бэлгийн эрсдэлт зан үйл нь мансуурлын үед нөхцөл байдлыг бодитоор

үнэлэх чадвар, өөрийгөө хянах чадвар, эрсдэлийн үнэлгээ алдагдахтай холбоотой юм.

Гэвч манай улсад мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн түвшин, түүнтэй холбоотой хүчин зүйлсийг үнэлсэн судалгаа хомс хэвээр байна. Иймээс мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийг тодорхойлох, түүнтэй холбоотой хүчин зүйлсийг илрүүлэх нь БЗДХ, ХДХВ-ийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах, зөвлөгөө, эрт илрүүлэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Зорилго: Мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн түвшинг тогтоож, түүнд нөлөөлж буй хүн амзүй болон зан үйлийн хүчин зүйлсийг тодорхойлох

Зорилт:

1. Мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн түвшин болон үндсэн хэлбэрүүдийг тодорхойлох.
2. Бэлгийн эрсдэлт зан үйлийн зарим хүчин зүйлсийг судлан тогтоох

Арга, аргачлал:

Судалгааны загвар: Судалгааг аналитк агшингийн загварыг ашиглан тохиолдолд суурилсан, зорилтот түүврийн холимог аргаар хийж гүйцэтгэв.

Судалгааны хамрах хүрээ, оролцогчид: Судалгааг 2025 оны 3 дугаар сарын 1-нээс 2026 оны 1 дүгээр сарын 1-ний хооронд явуулсан. Судалгаанд СЭМҮТ-д тусламж авч буй болон ШШГЕГ-т ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийг хамруулж, зорилтот болон тохиолдлын цуврал түүврийн аргаар, сайн дурын үндсэн дээр сонгов. Урьдчилан боловсруулсан удирдамжийн дагуу ганцаарчилсан ярилцлага зохион байгуулан мэдээлэл цуглуулахдаа хагас бүтэцчилсэн асуумж болон мансууруулах бодисын хэрэглээний эмгэгийг үнэлэх DAST (Drug Abuse Screening Test) сорилыг ашигласан. Хүн амзүй, бэлгийн зан үйл, согтууруулах ундааны хэрэглээ, бэлгийн боловсрол, БЗДХ-тай холбоотой үйлчилгээ, тохиолдлын хавьтал, сүүлийн 1 жилийн бэлгийн хавьтагчийн тоо зэрэг хувьсагчийг ашиглан үр дүнгийн статистик боловсруулалтыг Microsoft Excel болон SPSS 23 программд боловсруулж, дүрслэх статистик, χ^2 тест, параметр бус шинжилгээ, Спирманы корреляци, шугаман регрессийн загвар ашиглан үнэлсэн болно. Статистикийн ач холбогдлын түвшинг $p < 0.05$ гэж үзэв.

Ёс зүйн асуудал: Судалгааг түшиц байгууллагын зөвшөөрөлтэйгээр явуулж, АШҮҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөл авсан (24-25/05-02) болно.

Үрдүн: Судалгаанд мансууруулах бодисын хэрэглээтэй нийт 181 оролцогч хамрагдсанаас дийлэнх нь эрэгтэй (72.2%) байв. Насны бүтцийн хувьд, 25–34 (48.3%)

ба 18–24 насныхан (39.2%) хамгийн өндөр хувийг эзэлж байлаа. Оролцогчийн ихэнх нь хотод амьдардаг (94.4%); бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой (58.7%), гэрлээгүй (59.1%) байв. Нийт оролцогчийн


12.2% (n=22)-д бэлгийн эрсдэлт зан үйл илэрсэн буюу ойролцоогоор найман оролцогч тутмын нэг нь бэлгийн эрсдэлт зан үйлийн илрэлтэй болох нь тодорхойлогдсон (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Мансууруулах бодисын хэрэглээ бүхий оролцогчдын дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн байдал

Үзүүлэлт		Эрсдэлт зан үйлтэй n (%)	Эрсдэлт зан үйлгүй n (%)	X ² Рутга
Хүйс	Эрэгтэй	19 (14.6)	111 (85.4)	1.760
	Эмэгтэй	3 (6.0)	47 (94.0)	0.185
	18–24	6 (8.7)	63 (91.3)	4.818
Насны бүлэг	25–34	11 (12.9)	74 (87.1)	0.186
	35–44	4 (26.7)	11 (73.3)	
	45 ба түүнээс дээш	0 (0.0)	7 (100.0)	
Согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд ордог эсэх	Тийм	18 (18.4)	80 (81.6)	6.627
	Үгүй	3 (4.1)	70 (95.9)	0.010
Согтуугаар бэлгийн хавьталд орох давтамж	Үгүй/хааяа/заримдаа	11 (7.7)	132 (92.3)	28.210
	Ихэнхдээ/байнга	10 (55.6)	8 (44.4)	<0.001
Тохиолдлын бэлгийн хавьталтай байсан эсэх	Тийм	12 (28.6)	30 (71.4)	9.352
	Үгүй	6 (6.9)	81 (93.1)	0.002
Анхны бэлгийн хавьталд бэлгэвч хэрэглэсэн эсэх	Тийм	4 (7.1)	52 (92.9)	1.328
	Үгүй	18 (14.5)	106 (85.5)	0.249
Бэлгийн боловсрол авсан эсэх	Авсан	12 (11.5)	92 (88.5)	0.009
	Аваагүй	10 (13.2)	66 (86.8)	0.923

Бэлгийн эрсдэлт зан үйл бүхий мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн төлөв байдлыг тодруулан судлахад, эрчүүд (14.6%) болон 25-44 насныхан (12.9-26.7%) бусдаас илүү бэлгийн эрсдэлт зан үйл үйлддэг бөгөөд нийт оролцогчийн 18.4% нь согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд ордог ($p=0.010$); 55.6% нь согтуугаар бэлгийн хавьталд ихэнхдээ/байнга ордог ($p<0.001$); 28.6% нь тохиолдлын бэлгийн хавьталтай байсан ($p=0.002$) нь бэлгийн эрсдэлт зан үйлгүй бүлэгтэй харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа.

Бэлгийн эрсдэлт зан үйлийг үнэлэх асуумжийг нийт 177 оролцогч бүрэн бөглөсөн бөгөөд 37 нь (20.9%) дор хаяж нэг эрсдэлт зан үйлийг ихэвчилэн/байнга буюу тогтмол үйлддэг болохоо илэрхийлсэн байв. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчийн бэлгийн эрсдэлт зан үйлийг үнэлэх үнэлгээний нийлбэр онооны дундаж 8.13 ± 4.40 байсан ба нийлбэр онооны тархалтаас харахад оролцогчдын дийлэнх нь багаас дунд түвшний оноотой байсан нь тэд аль ч хэлбэрийн бэлгийн эрсдэлт зан үйлийг дангаар тогтмол үйлддэггүй болохыг илтгэж байна.



Зураг 1. Мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн хэлбэрүүд (эзлэх хувиар)

Зураг 1-д үзүүлсэнээр, мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийн хэлбэр тус бүрийн тархалтыг тодруулан судлахад, хамгаалалтгүй үтрээний бэлгийн хавьталд орох үзүүлэлт хамгийн (14.7%; $n=26$) их хувиар тодорхойлогдсон

бол хамгаалалтгүй амаар бэлгийн хавьтал үйлдэх (8.5%; $n=15$), мансууруулах бодис эсвэл бусад бодис хэрэглэсэн үедээ бэлгийн хавьтал үйлдэх (5.6%; $n=10$), согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн хавьтал үйлдэх (2.8%; $n=5$), саяхан танилцсан хүнтэй

бэлгэвчгүйгээр бэлгийн хавьтал үйлдэх (2.8%; $n=5$), хамгаалалтгүй шулуун гэдсээр бэлгийн хавьтал үйлдэх (1.1%; $n=2$) хэлбэрийн эрсдэлт зан үйл харьцангуй бага тархалттай байлаа. Иймээс судалгаанд хамрагдсан оролцогчдын дунд хамгийн түгээмэл илрэлтэй бэлгийн эрсдэлт зан үйл нь бэлгэвчгүйгээр үтрээний бэлгийн хавьтал үйлдэх байв.

Бэлгийн эрсдэлт зан үйлийг үнэлэх үнэлгээний нийлбэр оноог зарим хүчин зүйлстэй харьцуулан шинжлэхэд хүйс, хамтран амьдрагчтай эсэх, анхны бэлгийн хавьталд бэлгэвч хэрэглэсэн эсэх, согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд ордог эсэх, согтуугаар бэлгийн хавьталд орох давтамж, мөн тохиолдлын бэлгийн хавьталтай байсан эсэх үзүүлэлтүүдтэй статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байлаа. Тухайлбал, эрчүүдийн бэлгийн эрсдэлт зан үйлийн үнэлгээний дундаж оноо (8.63 ± 4.68); согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд ордог оролцогчдын дундаж оноо (9.04 ± 4.43); согтуугаар бэлгийн хавьталд ихэнхдээ/байнга ордог бүлгийн дундаж оноо (13.83 ± 5.70); тохиолдлын бэлгийн хавьталтай байсан бүлгийн дундаж оноо (10.31 ± 5.04) нь статистик ач холбогдол бүхий ялгаатай ($p \leq 0.001$) байв.

Түүнчилэн сүүлийн 1 жилийн хугацаан дах бэлгийн хавьтагчийн тоо ба бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр онооны хооронд сул эерэг хамаарал ажиглагдсан ($r=0.245$, $p=0.001$).

Бэлгийн эрсдэлт зан үйлийн илрэлийн түвшинг БЗДХ-тай холбоотой үзүүлэлтүүдтэй харьцуулан үзэхэд, “бэлгэвчгүйгээр үтрээний бэлгийн хавьтал үйлддэг” бүлэгт “сүүлийн 12 сард БЗДХ-ийн шинж тэмдэг илэрсэн байдал” статистикийн ач холбогдолтой ялгаатай байв ($p=0.007$). Мөн “саяхан танилцсан хүнтэй бэлгэвчгүй бэлгийн хавьталд ордог” оролцогчид сүүлийн 12 сард БЗДХ-ийн шинжилгээ өгсөн байх нь статистикийн ач холбогдолтой өндөр байв ($p=0.012$).

Сүүлийн 1 жилийн бэлгийн хавьтагчийн тоо болон бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр онооны хооронд илэрсэн хамаарлыг шугаман регрессийн загвараар үнэлэхэд, уг хувьсагч нь бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр онооны статистикийн ач холбогдол бүхий эерэг хамааралтай байв ($B=0.225$; 95% CI: 0.115–0.336; $p < 0.001$).

Хэлцэмж: Энэхүү судалгаагаар мансууруулах бодис хэрэглэгчдийн 12.2%-д бэлгийн эрсдэлт зан үйл илэрч, бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр онооны дундаж 8.13 ± 4.40 байв. Мөн оролцогчдын 20.9% нь дор хаяж нэг эрсдэлт зан үйлийг ихэвчлэн эсвэл байнга үйлддэг гэж мэдээлсэн нь энэхүү бүлгийн дунд бэлгийн эрсдэл жигд бус тархсаныг харуулж байлаа. Энэ үр дүн нь мансууруулах бодисын хэрэглээ нь хамгаалалтгүй хавьтал, олон хавьтагч, тохиолдлын бэлгийн хавьтал зэрэг эрсдэлтэй зан үйлтэй уялддаг талаар өмнөх олон улсын судалгааны дүгнэлттэй нийцэж байна^{2,5,6,10}.

Тус судалгааны гол үр дүнгийн нэг нь согтууруулах

ундаатай холбоотой бэлгийн зан үйл бэлгийн эрсдэлт зан үйлтэй хүчтэй хамааралтай байсан явдал юм. Согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд орох болон согтуугаар бэлгийн хавьталд орох давтамж нь бэлгийн эрсдэлт зан үйлийн хоёр ангилалт үзүүлэлт болон нийлбэр онооны аль алинд статистикийн ач холбогдолтой холбоотой байв. Энэ нь архины хурц хэрэглээ нь шүүлт, шийдвэр гаргалтыг сулруулж, эрсдэлтэй бэлгийн зан үйлийн магадлалыг нэмэгдүүлдэг талаар өмнөх судалгааны дүгнэлттэй нийцэж байна⁷⁻¹¹. Иймээс мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах бэлгийн эрсдэлт зан үйлийг бууруулахад зөвхөн бэлгийн эрүүл мэндийн боловсролоор хязгаарлагдахгүй, архи болон бусад бодисын хэрэглээтэй уялдсан хавсарсан сэргийлэлт шаардлагатай байна.

Түүнчлэн тохиолдлын бэлгийн хавьтал болон сүүлийн 1 жилийн бэлгийн хавьтагчийн тоо нь бэлгийн эрсдэлт зан үйлийн чухал хамааралт үзүүлэлтүүд байв. Манай судалгаанд тохиолдлын бэлгийн хавьталтай байсан бүлэгт бэлгийн эрсдэлт зан үйл 28.6% байсан бөгөөд нийлбэр оноо мөн өндөр байснаас гадна сүүлийн 1 жилийн бэлгийн хавьтагчийн тоо нэмэгдэхийн хэрээр бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр оноо өсөх хандлага ажиглагдаж, шугаман регрессийн шинжилгээнд эерэг үзүүлэлттэй байлаа. Энэ нь өмнөх судалгаануудад дурьдсанчлан олон хавьтагчтай байх, тогтворгүй хавьтагчтай байх, мөн метамфетамин болон бусад бодисын хэрэглээ нь өндөр эрсдэлтэй бэлгийн зан үйлтэй хавсардаг гэсэн үр дүнтэй нийцэж байна^{13-17,19}. Ялангуяа бодисын хэрэглээтэй хавсаран бэлгийн олон хавьтагч, хамгаалалтгүй хавьтал, БЗДХ-ын эрсдэл зэрэг нь цогцоор илрэх хандлагатайг сүүлийн үеийн судалгаанууд онцолсонтой тохирч байлаа²⁰.

Анхны бэлгийн хавьталд бэлгэвч хэрэглээгүй оролцогчдын бэлгийн эрсдэлт зан үйлийн нийлбэр оноо өндөр байсан нь хамгаалалтгүй зан үйлийн хэв маяг эрт үеэс бүрэлдэж, цаашдын бэлгийн зан үйлд нөлөөлж болзошгүйг харуулж байв. Бэлгийн эрсдэлт зан үйлийн хэлбэрүүдээс бэлгэвчгүйгээр үтрээний бэлгийн хавьтал хамгийн өндөр тархалттай байсан нь хамгаалалтын хэрэглээ хангалтгүй, сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн байдал статистикийн ач холбогдолтой ялгаатай гарсан нь эрсдэлт зан үйлийн эмнэлзүйн үр дагавар бодит түвшинд илэрч байж болзошгүйг илтгэж байна. Түүнчлэн саяхан танилцсан хүнтэй бэлгэвчгүй хавьталд ордог оролцогчдын дунд БЗДХ-ын шинжилгээ өгсөн хувь өндөр байсан нь тухайн бүлэг эрсдэлээ тодорхой хэмжээнд мэдэрч, шинжилгээнд хамрагдах хандлагатай байж болохыг харууллаа.

Энэхүү судалгааны давуу тал нь мансууруулах бодис хэрэглэгчдийн эмзэг бүлэгт бэлгийн эрсдэлт зан үйлийг хэд хэдэн түвшинд үнэлж, түүнийг зан үйлийн тодорхой хүчин зүйлүүд болон БЗДХ-тай холбоотой зарим үзүүлэлттэй холбон шинжилсэнд оршино. Харин агшингийн загвартай тул бэлгийн эрсдэлт зан

үйлийн учир шалтгаан, холбоо тогтоох боломж хомс, мэдээлэл нь асуумж судалгаанд суурилсан учир дутуу болон буруу мэдээлэх магадлалтай, мөн судалгаанд хамрагдсан оролцогчид нь нийт мансууруулах бодис хэрэглэгчдийг бүрэн төлөөлөхгүй байх боломжтой зэрэг хязгаарлагдмал талтай байв. Үүнээс гадна мансууруулах бодис хэрэглэгчид нь нуугдмал, хүрч ажиллахад бэрх бүлэгт хамаарах тул түүврийг бүрдүүлэхэд хүндрэлтэй байсан нь энэ төрлийн судалгаанд нийтлэг тулгамддаг асуудал юм²¹⁻²³.

Дүгнэлт: Мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд бэлгийн эрсдэлт зан үйл 12.2%-д илэрч, хамгийн түгээмэл хэлбэр нь бэлгэвчгүйгээр үтрээний бэлгийн хавьтал үйлдэх зан үйл байв. Согтууруулах ундааны нөлөөн дор бэлгийн хавьталд орох, согтуугаар бэлгийн хавьталд ихэнхдээ эсвэл байнга орох, тохиолдлын бэлгийн хавьталтай байх, мөн сүүлийн 1 жилийн бэлгийн хавьтагчийн тоо их байх нь бэлгийн эрсдэлт зан үйлтэй статистикийн ач холбогдолтой холбоотой байлаа. Иймээс мансууруулах бодис хэрэглэгчдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь архины болон бодисын хэрэглээтэй хавсарсан бэлгийн эрсдэлт зан үйлийг бууруулах, хамгаалалттай хавьтлыг дэмжих, БЗДХ-ын илрүүлэг, зөвлөгөө, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэх шаардлагатай байна.

Ном зүй

1. United Nations Office on Drugs and Crime. World Drug Report 2025: Key Findings. Vienna, Austria: United Nations Office on Drugs and Crime; 2025.
2. Brookmeyer KA, Haderxhanaj LT, Hogben M, Leichter JS. Sexual risk behaviors and STDs among persons who inject drugs: a national study. *Prev Med*. 2019;126:105779.
3. Kanno MB, Hooton TM, Roberts PL, Stamm WE, Holmes KK. Sexually transmitted diseases in injection drug users. *Infect Dis Clin North Am*. 2002;16(3):681-698.
4. Nelson KE, Vlahov D, Solomon L, Cohn S, Mucoz A. Sexually transmitted diseases in a population of intravenous drug users: association with seropositivity to the human immunodeficiency virus (HIV). *J Infect Dis*. 1991;164(3):457-463.
5. Leigh BC, Stall R. Substance use and risky sexual behavior for exposure to HIV: issues in methodology, interpretation, and prevention. *Am Psychol*. 1993;48(10):1035-1045.
6. Ritchwood TD, Ford H, DeCoster J, Sutton M, Lochman JE. Risky sexual behavior and substance use among adolescents: a meta-analysis. *Child Youth Serv Rev*. 2015;52:74-88.
7. Cunningham K, Stinson JD, Dziura J, et al. Alcohol use and sexual risk behaviors among adolescents with psychiatric disorders: a systematic review and meta-analysis. *J Child Adolesc Subst Abuse*. 2017;26(5):353-366.
8. Scott-Sheldon LAJ, Carey KB, Cunningham K, Johnson BT, Carey MP. Alcohol use and sexual risk behaviors among individuals infected with HIV: a systematic review and meta-analysis. *Curr HIV/AIDS Rep*. 2013;10(4):314-323.
9. Shuper PA, Joharchi N, Irving H, Rehm J. Acute alcohol consumption directly increases HIV transmission risk: a randomized controlled experiment. *J Acquir Immune Defic Syndr*. 2017;76(5):493-500.
10. Haider MR, Brown MJ, Harrison S, Yang X, Ingram L, Shahidullah M. Illicit drug use and sexually transmitted infections among young adults in the United States: evidence from a nationally representative survey. *Int J Environ Res Public Health*. 2020;17(15):5487.
11. Okoro UJ, Carey KB, Johnson BT, et al. Alcohol consumption, risky sexual behaviors, and HIV in Nigeria: a meta-analytic review. *Curr Drug Res Rev*. 2020;12(1):67-84.
12. Rajasingham R, Mimiaga MJ, White JM, Pinkston MM, Baden RP, Mitty JA. A systematic review of behavioral and treatment outcome studies among HIV-infected men who have sex with men who abuse crystal methamphetamine. *AIDS Patient Care STDs*. 2012;26(1):36-52.
13. Hittner JB, Owens EC. Meta-analysis of the association between methamphetamine use and high-risk sexual behavior among heterosexuals. *Psychol Addict Behav*. 2016;30(1):147-157.
14. Taylor MM, Aynalem G, Smith LV, Montoya JA, Kerndt PR. Methamphetamine use and sexual risk behaviours among men who have sex with men diagnosed with early syphilis in Los Angeles County. *Int J STD AIDS*. 2007;18(2):93-97.
15. Halkitis PN, Mukherjee PP, Palamar JJ. Longitudinal modeling of methamphetamine use and sexual risk behaviors in gay and bisexual men. *AIDS Behav*. 2009;13(4):783-791.
16. Fisher DG, Reynolds GL, Ware MR, Napper LE. Methamphetamine and Viagra use: relationship to sexual risk behaviors. *Arch Sex Behav*. 2011;40(2):273-279.
17. Moradi S, Moradi Y, Rahmani K, et al. Association between methamphetamine use and the number of sexual partners among men who have sex with men: a systematic review and meta-analysis. *Subst Abuse Treat Prev Policy*. 2022;17(1):24.
18. Ross MW, Wodak A, Darke S, Hall W. Sexually transmissible diseases in injecting drug users. *Genitourin Med*. 1991;67(1):32-36.
19. Mackesy-Amiti ME, Donenberg GR, Ouellet LJ. Sexual risk behavior associated with transition to injection among young non-injecting heroin users. *AIDS Behav*. 2013;17(7):2459-2466.
20. del Pozo-Herce P, Baca-Garcia E, Martinez-Sabater A, Chover-Sierra E, Gea-Caballero V, Curto-Ramos J, et al. Descriptive study on substance uses and risk of sexually transmitted infections in the practice of Chemsex in Spain. *Front Public Health*. 2024;12:1391390. doi:10.3389/fpubh.2024.1391390.
21. Navarrete MS, Adrian C, Bachelet VC. Respondent-driven sampling: Advantages and disadvantages from a sampling method. *Medwave*. 2022;22(1):e2528. doi:10.5867/medwave.2022.01.002528.
22. Rudolph AE, Nance RM, et al. Evaluation of respondent-driven sampling in seven studies of people who use drugs from rural populations: findings from the Rural Opioid Initiative. *Drug Alcohol Depend*. 2024.
23. Abdesselam K, Verdery A, Pelude L, Dhami P, Momoli F, Jolly AM. The development of respondent-driven sampling (RDS) inference: a systematic review of the population mean and variance estimates. *Drug Alcohol Depend*. 2020;206:107702.

Sexual risk behaviors and associated factors among people who use drugs (PWUD)

Bilguun N¹, Khongorzul D¹, Tergel Kh¹, Davaalkham J², Khishigsuren Z¹, Oyunsuren D¹

¹Department of Mental Health, School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

²HIV/STI Surveillance and Research Division, National Center for Communicable Diseases

E-mail: Bilguun.n@mnums.edu.mn, Tel: +976-95005413

Background: Substance use remains a critical public health and social concern, closely linked to increased sexual risk behaviors and a heightened vulnerability to sexually transmitted infections (STIs), particularly HIV and syphilis. International and national evidence suggests that individuals who use drugs often experience impaired judgment during intoxication, leading to unprotected intercourse, casual sexual encounters, and multiple sexual partners. In Mongolia, empirical data regarding sexual risk behaviors within this population remain scarce. Therefore, there is a pressing need to determine the prevalence of sexual risk behaviors and identify the specific factors influencing these patterns among drug users.

Materials and methods: This study employed a cross-sectional analytical design involving 181 participants who use drugs. Data were collected via structured questionnaires. Sexual risk behavior was evaluated using two approaches: as a dichotomous categorical variable and as a cumulative sexual risk score. Statistical analysis was performed using frequency distributions, percentages, means, and standard deviations. The associations between variables were tested using the (chi square test, Pearson correlation analysis, and multiple linear regression models.

Results: The findings revealed that 12.2% of participants exhibited high-level sexual risk behaviors, with a mean cumulative risk score of 8.13 ± 4.40 . Engaging in sexual intercourse while under the influence of alcohol, the frequency of intoxicated sex (reported as "often" or "always"), and a history of casual sexual encounters were significantly associated with sexual risk behaviors. Furthermore, gender, cohabitation status, condom use during the first sexual experience, and the frequency of alcohol-involved sexual encounters were statistically significant predictors of the cumulative risk score. A weak positive correlation was observed between the number of sexual partners in the past year and the cumulative sexual risk score, which remained a significant positive predictor in the linear regression model.

Conclusion: Sexual risk behavior among people who use drugs is more closely associated with behavioral factors—such as alcohol-influenced sexual activity, casual encounters, lack of condom use during sexual debut, and multiple partnership—than with basic socio-demographic characteristics. Consequently, risk reduction interventions should move beyond general awareness. Efforts must prioritize reducing substance- and alcohol-related sexual risks, promoting consistent condom use, and enhancing the accessibility of STI screening and counseling services tailored to this high-risk group.

Keywords: Substance abuse, High-risk sexual behavior, Alcohol-involved sex, STIs, HIV vulnerability, Risk reduction strategies